



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 388

Улаанбаатар хот

“Худалдаа хөгжлийн банк” ХХК-д  
кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 28.1, 63.1.5, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, Банкны тухай хуулийн 6.2, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 85/А-106 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Худалдаа хөгжлийн банк” ХХК-д үнэт цаасны зах зээлд кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.

2. Хөрөнгө оруулагч, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн, хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг чанд биелүүлж ажиллахыг “Худалдаа хөгжлийн банк” ХХК /Б.Мэдрээ/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000423